



Б Н М А У

УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ХУРЛЫН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ТОГТООЛ

1992 оны 01 сарын 23

№ 46.

Улаанбаатар
хот

"Алтай" компани байгуулах
тухай

БНМАУ-ын Аж ахуйн нэгжийн тухай хууль, МАХЕ-ын Төв Хо-
рооны нарийн бичгийн дарга нарын зөвлөлгөөний 1992 оны 9 дү-
гээр тогтоолыг үндэслэн Улаанбаатар хотын Ардын Хурлын гүй-
цэтгэх захиргаанаас ТОГТООХ нь:

1. Үйлчилгээний "Алтай" төвийг "Алтай" компани /УУГ/
болгон 1992 оны 2 дугаар сарын 1-нээс зохион байгуулсугай.

2. "Алтай" компан /УУГ/-ийн дүрмийг хавсралт ёсоор
баталсугай.



УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН
ХУРЛЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИР-
ГААНЫ ДАРГА,

ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН
ДАРГА

Л.ЭНХБАТ

Ц.БОЛДСАЙХАН

90

Улаанбаатар хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргааны 1992 оны 26 дугаар тогтоолын хавсралт.

**УЛААНБААТАР ХОТЫН АЛТАЙ КОМПАНИЙН
"УҮГ"-ЫН ДҮРЭМ**

Нэг. Нийтдэгт үндэслэл

I. Улаанбаатар хотын Алтай компани /УҮГ/ энэ дүрэмд цаашид "компани" гэнэ/ нь зочид буудлын ашиглалт, үйлчилгээний ажил эрхлэхээс гадна жижиг үйлдвэрлэл зохион байгуулж үйлчилгээ үйлдвэрлэлийн хавсарсан үйл ажиллагааг төрийн өмчинд тулгуурлан явуулах байгууллага байна.

Хоёр. Удирдлага зохион байгуулалт

I. Компани нь өөрөө өөрийгөө санхүүжүүлэн аж ахуйн бүрэн тооцсон дээр бие даан ажиллаж зочид буудлын ашиглалт үйлчилгээ, жижиг үйлдвэрлэл явуулах асуудлаар байгууллагууд болон хувийн аж ахуй эрхлэгчидтэй хорших, цахилгаан, сантехникийн төхөөрөмж, өрөө тасалгааны засварыг өөрийн хүчээр гүйцэтгэх нэгж салбартай ажиллана.

2. Компани нь үйл ажиллагаандаа Монгол улсын хууль тогтоомж, Улаанбаатар хотын Ардын Хурлын Тэргүүлэгчид, гүйцэтгэх захиргаанаас гаргасан эрх зүйн акт болон энэхүү дүрмийг удирдлага болгоно.

3. Компани нь бие даасан данстай, тогтоосон журмын дагуу хийгдсэн тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэж тушаал гаргана.

Компанийн үйл ажиллагааг захиран удирдаж Улаанбаатар хотын Ардын Хурал, гүйцэтгэх захиргааны өмнө ажил хариуцан тайлагнана.

4. Компанийн захирлыг Улаанбаатар хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргаа гаргээний үндсэн дээр томилно.

5. Компани нь 5-7 хүний бүрэлдэхүүнтэй зөвлөл байна.

Гурав. Компанийг байгуулах, бүртгэх

I. Компанийг Улаанбаатар хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргааны санаачлага, шийдвэрээр байгуулна.

- 2. Компани нь татварын улсын албанд бүртгүүлнэ.

Дөрөв. Компаний эд хөрөнгө.

I. Компаний эд хөрөнгө нь үндсэн ба эргэлтийн хөрөнгө санхүүгийн бусад нөөцөөс бүрдэнэ. 1992 оны II-р сарын байдлаар дүрмийн сан 5786,7 мянган төгрөг байна. Өөрийн мэдлийн эд хөрөнгөө Монгол улсын хууль тогтоомж болон энэхүү дүрмэндээ нийцүүлэн үйл ажиллагааныхаа чиглэлийн дагуу эзэмшин ашиглаж, захиран зарцуулна.

Тав. Компаний үүрэг

1. Өөрийн харьяанд аж ахуйн нэгжийг байгуулах, татан буулгах, өөрчлөх асуудлыг бие даан шийдвэрлэнэ. Аж ахуйн нэгжийн даргыг гэрээний үндсэн дээр компаний захирал томилно.

2. Компани нь зочил буудлыг ашиглалт, үйлчилгээний чанарыг сайжруулах, тасралтгүй хэвийн үйл ажиллагааг хангах, зочил буудлын тохижилтын түвшинг дээшлүүлэх, шинэ техник технологи, тавилга төхөөрөмж нэвтрүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлнэ.

3. Аж ахуйн үйл ажиллагааны тайлан тэнцэл статистикийн мэдээт тогтсон журмын дагуу үнэн зөв мэдээлж байх, санхүүгийн үйл ажиллагаанд судалгаа дүгнэлт, хяналт хийж шаардлагатай арга хэмжээ авна.

4. Араа түрээсийн хэлбэрийг өргөжүүлж үйлдвэрлэл үйлчилгээний үр ашгийг нэмэгдүүлэх, ажиллагсадын хөлөлмөрийн нөхилийг сайжруулах, нийгмийн асуудлыг шийдвэрлэх, арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.

5. Ажилтан, ажилчдад цалин хөлсийг олгохдоо мөрдөгдөж байгаа тариф мэргэжлийн лавлахыг баримтлахын зэрэгцээ үйлдвэрлэл, үйлчилгээний үр ашигтай холбогцуулан цалин хөлсийг өсгөх бууруулах арга хэмжээг цаг тухайд нь авч хэрэгжүүлнэ.

6. Өөрийн байгууллагын мэргэжилтэн боловсон хүчнээр бэхжүүлэх, тэднийг шилж сонгох, мэргэжил мацлагийг нь дээшлүүлэх бодлогыг явуулж хэрэгжүүлнэ.

Зургаа. Компаний эрх.

Зочил буудлын тохижилтын түвшинг дээшлүүлэх, үйлчилгээ үйлдвэрлэлийг өргөтгөн боловсронгуй болгохын тулд гадаадын нүүс, хоршоо, хувийн аж ахуйтантай хорших, хамтран ажиллах хэлбэрийг ашиглана.

2. Дээшилт техник, технологи нэвтрүүлэхэд гадаадын патент, лицензийг ашиглах, техникийн шинэчлэлийг цаг алдалгүй хийхэд банкны зээл валютын зээл ашиглана.

Долоо. Компанийг өөрчлөн байгуулах татан буулгах

1. Компанийг өөрчлөн байгуулах татан буулгах асуудлаар Улаанбаатар хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргаа шийдвэрлэнэ.